






**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН**

2023.12.14

Д/д	Зорилго	№	Хэрэгжүүлэх ажил	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Биелэлт	Нотлох баримт	Биелэлт хувь
1/.	Авлигын эсрэг сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, авлигыг үл тэвчих ёс зүйг төлөвшүүлэх	1.1	Авлигын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагаа: Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, зохиомж, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг компанийн веб хуудас, пэйж, фэйсбүүк зэрэг нийгмийн цахим сүлжээгээр, боломжит хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх, Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар, нэгжийн онцлогт тохируулан зохион байгуулах;	Дэмжин ажилласан үр дүнг тайлагнана (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)  /Тайланд баримтжуулсан байх/	Монгол Улсын Авлигатай тэмцэх газар (“АТГ”)-ын цахим хуудас ( <a href="https://www.iaac.mn">https://www.iaac.mn</a> )-т гарсан мэдээ, мэдээллийг компанийн нийт ажилтнуудад тухай бүр тогтмол танилцуулж, АТГ-ын цахим хуудсыг компанийн <a href="http://www.khkhap.mn">http://www.khkhap.mn</a> цахим хуудасны авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл цэстэй холбож, иргэд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн. Компанийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний жилийн биелэлтийн тайланг хүргүүлэх өдрийн байдлаар тус мэдээллийн самбарын дагуу гомдол, мэдээлэл ирээгүй болно. Тайлант хугацаанд компанийн <a href="http://www.khkhap.mn">http://www.khkhap.mn</a> цахим хуудас авлигаас урьдчилан сэргийлэх 4 мэдээ, авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, фэйсбүүк хуудасны ковер зургийг “Авлигын эсрэг нэгдье” зургаар сольж, авлигаас урьдчилан сэргийлэх 5 мэдээ, 1 бичлэгийг тус тус байршуулан иргэд, олон нийтийг нээлттэй танилцах боломжоор хангасан. Үүнд: 1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авахад олон нийтэд тулгарч байсан хүнд суртлыг арилгажээ. 2. Авлигын эсрэг “НЭГДЬЕ” соён гэгээрүүлэх аяныг эхлүүллээ.	<p><a href="https://khkhap.mn/content/74">https://khkhap.mn/content/74</a>  <a href="https://khkhap.mn/content/show/id/320">https://khkhap.mn/content/show/id/320</a>  <a href="https://khkhap.mn/content/show/id/332">https://khkhap.mn/content/show/id/332</a>  <a href="https://khkhap.mn/content/show/id/333">https://khkhap.mn/content/show/id/333</a>  <a href="https://khkhap.mn/content/show/id/334">https://khkhap.mn/content/show/id/334</a>  <a href="https://www.facebook.com/KhushigiinKhundii">https://www.facebook.com/KhushigiinKhundii</a></p>  <p>10:34      &lt; Хөшигийн хөндийн нисэх он...      Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал      4K likes · 4.4K followers      Message Liked</p>	100

				<p>3. Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний алба нь 2023 оны 4 дүгээр сарын 24-30-ны өдрүүдэд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 101 өргөдөл, гомдлыг хүлээн авч, харьяалах чиг үүргийн нэгжид хүргүүлээ.</p> <p>4. Өнгөрсөн долоо хоногт төрийн байгууллагын 1464 албан тушаалтанд авлигын эсрэг сургалт зохион байгууллаа.</p> <p>5. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс 2023 оны 11 дүгээр сарын 27-оос 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд гэмт хэргийн шинжтэй 111 гомдол, мэдээллийг шалгав. Үүнээс 17 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 12 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт шилжүүлсэн бөгөөд одоогоор 82 гомдол, мэдээллийг хянан шалгаж байна.</p>			
		1.2	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх;</p>	<p>Мэдээллийг тогтмол шинэчилсэн байх; Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргах</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” уриа, “Авлигын эсрэг нэгдье” аяны мэдээллийн самбарыг компанийн төв оффис болон “Чингис хаан” олон улсын нисэх буудлын Хүндэт зочны танхимын мэдээллийн самбарт тус тус байршуулсан. Мөн АТГ-аас зохион байгуулж буй аяны талаарх шинэ мэдээ, мэдээлэл, гаргасан видео контентыг тухай бүр компанийн фэйсбүүк хуудас болон вэб хуудсанд тогтмол байршуулж байна.</p>		100

		<p>1.3</p> <p>Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх;</p>	<p>Нэгдсэн, хамрагдсан санал, санаачилга, уриа, аяны нэр, тоо</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” уриа, “Авлигын эсрэг нэгдье” аяны мэдээллийн самбарыг компанийн төв оффис болон “Чингис хаан” олон улсын нисэх буудлын Хүндэт зочны танхимын мэдээллийн самбарт тус тус байршуулж, компанийн ажилтнуудад АТГ-аас гаргасан уриа, аяныг тухай бүр танилцуулж мэдээллийг хүргэсэн. Компанийн фэйсбүүк хуудас нь 4400 дагагч, 4900 like-тай бөгөөд давхардсан тоогоор 9300 хүнд мэдээлэл хүрсэн байна.</p>		<p>100</p>
		<p>1.4</p> <p>Алба хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх ёс зүйн сургалт, Авлигатай тэмцэх газар, Зам, тээвэр хөгжлийн яамнаас зохион байгуулах сургалтад хамруулах.</p>	<p>Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо</p>	<p>1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2020 оноос эхлэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлснээр гарч буй зөрчил, дутагдлыг арилгах талаарх АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны ажилтан, комиссар Б.Соёлмаагаас 2023.03.20-ны өдөр ирүүлсэн зөвлөмжийг судалж танилцан ЭБАТ хариуцсан албан тушаалтан хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн компанийн ХАСХОМ бөглөх эрх бүхий албан тушаалтнуудад хамааралтай мэдээлэл зааварыг хүргүүлж танилцуулсан.</p> <p>2. АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албанаас ZOOM-ээр 2023.05.29-ний өдөр зохион байгуулсан 2023 онд шинээр томилогдсон ЭБАТ-уудад зориулсан сургалтад СЗУХ-ийн дарга С.Батчимэг, 2023.09.26-ны өдөр зохион байгуулсан ижил төрлийн сургалтад СЗУХ-ийн дарга С.Батчимэг, Захиргаа,</p>		<p>100</p>

				<p>Хуулийн ахлах мэргэжилтэн Э.Энхжаргал НБЗХ-ийн дарга А.Баасандагва нар тус тус хамрагдаж, сургалтын материалыг судлан, шаардлагатай зарим мэдээллийн хүрээнд санхүү, захиргааны холбогдох ажилтнуудад мэдээлэл өгч, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.</p> <p>3. Авлигын эсрэг “Нэгдье” аяны хүрээнд 2023.11.30-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (“ТӨБЗГ”), АТГ, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээнд СЗУХ-ийн дарга С.Батчимэг, Захиргаа, Хуулийн ахлах мэргэжилтэн Э.Энхжаргал, Эдийн засагч Б.Цогт нар оролцсон ба АТГ-ын АТҮХХ-ийн албаны дарга, эрхэлсэн комиссар Ц.Шинэбаярын танилцуулсан, 2023.06.30-ны өдөр Улсын Их Хурлын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он)”-ийг судалж, төрийн өмчит хуулийн этгээдэд хамаарах 8 дугаар зорилгын хүрээнд компанид хамааралтай үйл ажиллагааг ирэх оны төсөв, төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна. Түүнчлэн, тус “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн талаар компанийн нийт ажилтнуудад танилцуулж мэдээлэл хүргэсэн. Давхардсан тоогоор дээрх 3 сургалтад нийт 6 ажилтан хамрагдсан байна.</p>		
2/.	Хууль тогтоомжийн биелэлтийг хангах	2.1	Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх хянах, зөвлөгөө өгөх асуудлыг хэрэгжүүлэх;	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж баталгаажуулсан байх		100

		2.2	Мөрдөгчийн мэдээллийн дагуу ажил зохион байгуулах, зөрчил арилгуулах, зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлэх.	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайлан мэдээг хүргүүлсэн байх	Компанийн хувьд тайлант хугацаанд мөрдөгчийн мэдээлэл, зөрчил арилгуулах мэдэгдэл авсан тохиолдол байхгүй болно.		100
3/.	Компанийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, Засгийн газрын авлигатай тэмцэх 5 үйл ажиллагааны “Шил”, “Шүүр” ажиллагааг дэмжин ажиллах	3.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтыг мөрдөж ажиллах;	Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. Нийт мэдээлсэн мэдээллийн төрөл, тоо	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийт 143 мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд ил тод мэдээлсэн. Сар бүр 2 мэдээ, жил бүр 7 мэдээ, хагас жил бүр 3 мэдээ, тухай бүр тус тус 10 мэдээ, нийт 143 мэдээллийг байршуулсан. Хугацаа хоцроосон болон байршуулаагүй, дутуу байршуулсан мэдээ, мэдээлэл байхгүй болно. 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын шилэн дансны тайланг гаргаж Зам, тээврийн хөгжлийн яам (“ЗТХЯ”) болон Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн.	<a href="https://shilendans.gov.mn/organization/26024">https://shilendans.gov.mn/organization/26024</a> “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2023 оны 1 дүгээр улирлын шилэн дансны тайланг ЗТХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (“ХШҮДАГ”)-т 2023.04.20-ны өдрийн 01/58 тоот албан бичгээр, 2023 оны 2 дугаар улирлын шилэн дансны тайланг 2023.07.07-ны өдрийн 01/94 тоот албан бичгээр, 2023 оны 3 дугаар улирлын шилэн дансны тайланг 2023.10.09-ний өдрийн 01/128 тоот албан бичгээр тус тус хүргүүлэв.	100
		3.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг байгууллагын албан ёсны цахим	Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна, Мэдээлсэн нээлттэй мэдээллийн төрөл, тоо	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нийтэд нээлттэй мэдээлэх 98 мэдээллээс компанийн үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах 62 мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд компанийн <a href="http://khkhap.mn">http://khkhap.mn</a> вэб хуудас, шилэн данс ( <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> ), <a href="http://tender.gov.mn">tender.gov.mn</a> цахим системд тус тус байршуулж, хэрэгжилтийн мэдээ тайланг сар бүр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т цахимаар хүргүүлж байна. Мөн 2023 оны хагас жил,	<a href="https://khkhap.mn/">https://khkhap.mn/</a> 2023 оны эхний хагас жилийн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн хэрэгжилтийг ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2023.06.16-ны өдрийн 01/80 дугаартай албан бичгээр, 2023 оны хэрэгжилтийг 2023.12.12-ны өдрийн 01/165 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	100

		хуудсанд тогтмол байршуулах;		жилийн тайланг албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн.		
	3.3	Байгууллагын цахим хуудасны мэдээллийг шинэчлэх;	Цахим хуудсанд шинэчилсэн мэдээллийн төрөл, тоо	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд компанийн эрхэм зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, зохион байгуулалтын бүтэц, компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, цаг үеийн мэдээ мэдээлэл, хүний нөөц, ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт, авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээлэл зэрэг нээлттэй байршуулахаар хуульд заасан мэдээллийг <a href="http://khkhap.mn">http://khkhap.mn</a> вэб хуудаст бүрэн байршуулж иргэд, олон нийт мэдээлэл авах, танилцах боломжоор бүрэн хангасан.</p> <p>2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд ажлын байрны сонгон шалгаруулалтын 17, цаг үеийн 57 мэдээ, мэдээлэл, бусад төрлийн 69 ил тод мэдээлэх шаардлагатай мэдээллүүдийг <a href="https://khkhap.mn/content">https://khkhap.mn/content</a> вэб хуудаст байршуулсан.</p> <p>Компанийн “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК” фэйсбүүк хуудаст нийт 270 мэдээ, мэдээллийг байршуулсан байна.</p>	<a href="https://khkhap.mn/">https://khkhap.mn/</a> <a href="https://www.facebook.com/KhushigiinKhundii">https://www.facebook.com/KhushigiinKhundii</a>	100
	3.4	Өргөдөл гомдлыг цахим хуудсаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, ирүүлсэн өргөдөл гомдлыг тухай бүр шийдвэрлэж хариу өгөх;	Ирсэн, шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	<p>АТГ-ын цахим хуудас (<a href="https://www.iaac.mn">https://www.iaac.mn</a>)-т гарсан мэдээ, мэдээллийг компанийн нийт ажилтнуудад тухай бүр тогтмол танилцуулж, АТГ-ын цахим хуудсыг компанийн <a href="http://www.khkhap.mn">http://www.khkhap.mn</a> цахим хуудасны авлигаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл цэстэй холбож, иргэд, олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Одоогоор тус мэдээллийн самбарын дагуу гомдол, мэдээлэл ирээгүй болно.</p>	<a href="https://khkhap.mn/content/95">https://khkhap.mn/content/95</a> <a href="https://khkhap.mn/content/show/id/279">https://khkhap.mn/content/show/id/279</a>	100

		3.5	Ажлын байрны сул орон тоонд ажилтан сонгон шалгаруулах журмыг нээлттэй болгож, үйл ажиллагаандаа мөрдөх;	Сул орон тооны нээлттэй сонгон шалгаруулалтын тоо, мэдээлэл	Компани нь ажлын байрны сул орон тоонд ажилтан сонгон шалгаруулахдаа журмын дагуу сонгон шалгаруулалтыг нээлттэй явуулж хэвшсэн ба сул ажлын байрны зарыг компанийн <a href="http://www.khkhap.mn">http://www.khkhap.mn</a> цахим хуудасны Ил тод байдал - Хүний нөөц- “Нээлттэй ажлын байр” цэс хэсэгт, мөн “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК” фэйсбүүк хуудаст байршуулан иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж, танилцах, анкетаа ирүүлэх боломжоор бүрэн хангадаг. Түүнчлэн, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн Монголын иргэн бүрд нээлттэй “Zangia.mn” ажлын байрны зарын нэгдсэн сайттай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж ажлын байрны зарыг тогтмол байршуулж эхэлсэн. Тайлант хугацаанд буюу 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл хугацаанд “Үйлчилгээний ажилтан”-ы сул орон тоонд нээлттэй зарын дагуу нийт 75, “Үйлчилгээний туслах ажилтан” ажлын байранд нийт 5, “Жолооч” ажлын байранд нийт 11, “Захиргаа, Хуулийн ахлах мэргэжилтэн” ажлын байранд нийт 87, “Санхүүгийн шинжээч” ажлын байранд нийт 21, “Тооцооны нягтлан бодогч” ажлын байранд нийт 10 ажил горилогч бүрэн ба бүрэн бус анкет, материалаа ирүүлсэн байна. Компанийн “Хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу сул ажлын байранд ажил горилогчдын сонгон шалгаруулалтыг явуулж, 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар Г.Дэлгэрзаяа, В.Билгүүн, П.Ариунбуян, Г.Намсрай, Б.Хишигбадрах, Д.Халиун, М.Одгэрэл, Э.Цэмбэл, Ш.Балдорж, Н.Наранзул, Б.Долгор, Н.Номин, Б.Галбадрах нарыг Үйлчилгээний ажилтан, У.Буяндэлгэрийг Жолооч, Э.Энхжаргалыг	<a href="https://khkhap.mn/content/32">https://khkhap.mn/content/32</a> <a href="https://khkhap.mn/content/show/id/192">https://khkhap.mn/content/show/id/192</a> <a href="https://www.facebook.com/KhushigiinKhundii">https://www.facebook.com/KhushigiinKhundii</a> <a href="https://www.zangia.mn/company/Khushigiin-khundii-airport-SOLLC">https://www.zangia.mn/company/Khushigiin-khundii-airport-SOLLC</a>	100
--	--	-----	--	---	--	--	-----

				Захиргаа, Хуулийн ахлах мэргэжилтэн, Б.Бадамыг Тооцооны нягтлан бодогч ажлын байранд тус тус сонгон шалгаруулж, Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулсан ба одоогоор Г.Дэлгэрзаяа, В.Билгүүн, П.Ариунбуян, Г.Намсрай, Д.Халиун, М.Одгэрэл, Э.Цэмбэл, Ш.Балдорж, У.Буяндэлгэр, Э.Энхжаргал нарын туршилтын гэрээний хугацааг дуусгавар болгож үндсэн ажилтнаар жинхлэн үргэлжлүүлэн Хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулсан.		
		3.6	Албан тушаалын тодорхойлолт /АТТ/ уудыг шинэчлэн боловсруулах, АТТ-д заасан шаардлагыг хангахгүй байгаа ажилтнуудыг сэлгэн ажиллуулах боломж нөхцөлийг судлах, хууль журамд заасны дагуу шийдвэрлэх.	АТТ-уудыг шинэчилсэн байна. Шүүр ажиллагааны хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн байна.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны ХЭХТ22/07 тогтоолоор батлагдсан “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн бүтэц, орон тооны дагуу нийт 41 ажилтны ажлын байр, 22 албан тушаалаас 19 албан тушаалын тодорхойлолтыг 2023 оны 01 дүгээр сард холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэн баталсан. Компанийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан орон тооны хэмнэлт хийх шаардлага бий болж 6 сул ажлын байр, орон тооны сонгон шалгаруулалтыг түр хугацаагаар хойшлуулсан. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласнаар зохион байгуулагдаж буй “5Ш” ажиллагааны ”ШҮҮР” ажиллагаанд 03 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд хамрагдаж, ажлын байранд ЗТХЯ-ны хяналт шалгалтын 6 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж ажилласан бөгөөд мөн ТӨБЗГ-т шүүр ажиллагааны холбогдох баримт материалыг ирүүлсэн жагсаалтын дагуу цаасаар 2023.03.31-ний өдрийн 01/49 тоот албан бичгээр хүргүүлсэн. “Шүүр” ажиллагааны хүрээнд компанийн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, хүний нөөц, авлига, ашиг сонирхлын зөрчил зэрэгт холбогдох	100



					бүх тушаал, шийдвэр, баримт бичиг, архивын баримт, мэдээллийг хянаж тулган шалгасан ба манай компанийн хувьд ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй болно.		
4/.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1	Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцэст тооцож биелэлтийг тайлагнана;	Төлөвлөгөө, тайланг танилцуулж, хүргүүлсэн байна. Тайланд нотломжийг хавсаргах	Компанийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г 2023.01.20-ний өдөр АТГ-т <a href="mailto:turbulag@iaac.mn">turbulag@iaac.mn</a> имэйл хаягаар хүргүүлж, тус газраас төлөвлөгөөний төслийг хянаж ирүүлсэн саналыг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр цахимаар хүлээн авч тусган төлөвлөгөөг эцэслэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийг 2023.06.16-ны өдрийн 01/80 дугаартай албан бичгээр АТГ, ЗТХЯ-нд тус тус хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний жилийн биелэлтийг энэхүү тайлангаар хүргүүлж байна.	<a href="https://khkhap.mn/content/34">https://khkhap.mn/content/34</a> <a href="https://khkhap.mn/content/35">https://khkhap.mn/content/35</a>	100
		4.2	Авлигатай тэмцэх газар, салбарын яамнаас ирүүлсэн санал, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, төлөвлөгөө, холбогдох дүрэм журамд тусгах;	Тусгасан санал, зөвлөмж -Тайланд нотломжийг хавсаргах	АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албанаас 2023.03.20-ны өдөр ХАСУМ-ыг цахимаар гаргахад анхаарах зүйл, зөвлөмж, 2023.05.29 болон 2023.09.26-ны өдрийн шинэ ЭБАТ-уудад зориулсан Zoom сургалтын зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Компанийн “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-нд АТГ-аас ирүүлсэн саналыг тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 онд тус компанид өнөөдрийн байдлаар АТГ-аас болон ЗТХЯ-аас тусгайлсан санал, зөвлөмж, чиглэл ирүүлээгүй болно.		100

		4.3	<p>Авлигын эрсдэл үүсэх шалтгаан нөхцөлийг бий болгохгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ, зөвлөмж бэлтгэх, шийдвэр гаргах процесс, байгууллагын дотоод хяналт, зохион байгуулалтыг сайжруулах;</p>	<p>Байгууллагын дотоод үйл ажиллагаа, шийдвэр гаргах процесст удирдах албан тушаалтнуудын хамтын удирдлага хяналтыг бий болгосон байна.</p>	<p>Компанийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнээр 2023 оноос эхлэн СЗУХ-ээс авлигын эрсдэл үүсэх шалтгаан нөхцөлийг бий болгохгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан тушаалаа урвуулан ашиглахаас сэргийлэх, албан тушаалтны ажил үүргийн хариуцлагыг дээшлүүлэх үндсэн зорилгоор компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэр гаргалт, гэрээ хэлцэл байгуулах, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд Гүйцэтгэх захирал, хэлтэс, албаны дарга нар давхар хяналт тавьж, хамтын шийдвэрээр, удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх ажиллагааг багаар гүйцэтгэж, давхар хяналтыг хэрэгжүүлэн, нэг албан тушаалтан дангаар хариуцан хэрэгжүүлэх, шийдвэр гаргахаас зайлсхийх байдлаар ажил үүргийг зохион байгуулан ажиллаж байна. Хэлтэс, албаны чиг үүргийн дагуу хамтын оролцоог хангах, хариуцлагыг дээшлүүлэх замаар дотоод хяналтын зохион байгуулалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	<p>100</p>
		4.4	<p>Аливаа гэрээ хэлцлийг байгуулахад авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах.</p>	<p>Худалдан авах ажиллагааны журмыг баримтлан ажиллаж, гэрээ байгуулахдаа авлигаас ангид байх асуудлыг тусгах; авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх, гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн</p>	<p>2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй бүх гэрээ хэлцэлд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хэрэв ашиг сонирхлын зөрчил бий болох, бий болж болзошгүй нөхцөлд гэрээ хэлцэл хийхээс татгалзах, албан тушаалтны удирдлагад мэдэгдэх талаар тусгайлсан тодорхой нөхцөл, заалтуудыг оруулж эхлэн, хэвшүүлсэн. Гэрээлэгч байгууллага иргэдэд гэрээний үүрэг харицлагад тусгасан авлига албан тушаалын хамаарал нөлөөнөөс ангид байх, аливаа эрхийн зөрчилгүй байхыг сануулж зохих хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 13 хуулийн этгээд, 4 иргэнтэй нийт 22 гэрээ</p>	<p>4.7. Захиалагч, түүний удирдлага, эрх буй албан тушаалтан нь Ажил гүйцэтгэлтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх ба хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүн болгоогүй нөхцөлд энэ тухайгаа мэдэгдэх, гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.</p> <p>5. Ажил гүйцэтгэчийн эрх, үүрэг</p> <p>3.1.9 Түрээслэгч, түүний удирдлага, эрх буй албан тушаалтан нь түрээслүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчилгүй байх ба хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүн болгоогүй нөхцөлд энэ тухайгаа мэдэгдэх, гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.</p> <p>3.2. Түрээслэгчийн эрх:</p> <p>4.5. Үйлчилгээг, түүний удирдлага, эрх буй албан тушаалтан нь Энхэлж, түүний удирдлага, эрх буй албан тушаалтантай ашиг сонирхлын зөрчилгүй байх ба хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүн болгоогүй нөхцөлд энэ тухайгаа мэдэгдэх, гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.</p> <p>Тав. Энхэлжний хууль эрх, үүрэг</p> <p>2.16 Ажил гүйцэтгэгч нь авлигаас, түүний удирдлага, эрх буй албан тушаалтантай ашиг сонирхлын зөрчилгүй байх ба хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүн болгоогүй нөхцөлд энэ тухайгаа мэдэгдэх, гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.</p> <p>ГҮРАА, ХАМБАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА</p> <p>100</p>

			<p>төлүүлэх асуудлыг тусгасан байх; Тайланд нотломжийг хавсаргах.</p>	<p>байгуулж, гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага хэсэгт тусгайлсан нөхцөл, заалтуудыг оруулсан байна. Сонирхлын зөрчилтэй 2 гэрээг (Зээлийн гэрээ, Ашиглалтын гэрээ) Монгол-Японы хамтарсан “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-тай байгуулсан ба СЯ, компанийн Хувьцаа эзэмшигчид болох ЗТХЯ, ТӨБЗГ-ын төрийн өмчийн төлөөлөгчдөөс зөвшөөрөл авсан болно.</p>	<p>Зээлдэгч нь Энхүү Гэрээг байгуулж, зээл авахаас өмнө өөрийн хувьцаа эзэмшигчид болон бусад шаардлагатай төрийн байгууллагуудад зөвхөн зөвшөөрлийг авах бөгөөд энэ талаар Зээлдүүлэгчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон Зээлдүүлэгчид мэдэгдэж, зөвшөөрлийн хуудсыг Зээлдүүлэгчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Зээлдүүлэгчид хүргүүлсэн байна.</p> <p>6.2 After receiving the approval and notification in accordance with Article 6.1, the matter of granting loan shall be discussed at the meeting of the Board of Directors of the Lender and the approval of concluding the loan agreement and granting the loan shall be obtained by the Lender.</p> <p>Гэрээний 6.1-д заасны дагуу зөвшөөрөл, мэдэгдлийг хүлээн авсны дараа Зээлдүүлэгч нь зээл олгох асуудлыг Зээлдүүлэгчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зээлийн гэрээг байгуулах, зээл олгох зөвшөөрлийг авна.</p> <p>6.3 Prior to entering into this Agreement and granting the loan, this matter must be discussed at Board of Directors meeting of the Lender and the relevant permission must be obtained. Энхүү Гэрээг байгуулж, зээл олгохоос өмнө энэ асуудлыг Зээлдүүлэгчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох зөвшөөрлийг авсан байх шаардлагатай.</p>	
<p>Компанийн 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааг 4 зорилгын хүрээнд 16 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тайлант жилийн туршид нийт төлөвлөсөн ажил, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, биелэлт <b>100%</b>.</p>						

---ooOoo---